

**БАТЛАВ.**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА \_\_\_\_\_ / А.ЭНХБАТ /

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.**

“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ \_\_\_\_\_



/ Н.БИЛГҮҮН / - 2

**“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН 1-Р БАГИЙН  
НУТАГТ БАЙРЛАХ “ХИМИЙН ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ, ДАХИН  
БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР” ТОДОТГОЛ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2066521/**

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-Н МЭРГЭЖИЛТЭН \_\_\_\_\_ / П.ШИНЭЦЭЦЭГ /

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“ДЭЭШЛЭХ ГОВЬ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ \_\_\_\_\_ / ДЭЭШЛЭХ / Ж.ЦЭВЭЭНЖАВ /

“ДЭЭШЛЭХ ГОВЬ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН  
/ Р.БААСАНЦЭРЭН /



2023 он

## ГАРЧИГ

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл .....	3
1.2	Төслийн хүчин чадал: .....	4
1.3	Төслийн технологи: .....	4
1.4	Түүхий эд, туслах материал: .....	5
1.5	Эцсийн бүтээгдэхүүн.....	6
1.6	Тоног төхөөрөмж.....	6
1.7	Хог хаягдал .....	7
2.	ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	8
2.1	Уур амьсгал.....	8
2.2	Геологийн тогтоц ба геоморфологи.....	8
2.3	Гадаргын ус.....	9
2.4	Газрын доорх ус.....	10
2.5	Хөрсөн бүрхэвч.....	10
2.6	Ургамлан нөмрөг .....	10
2.7	Амьтны аймаг .....	11
2.8	Нийгэм, эдийн засаг.....	11
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ.....	13
3.1	Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл .....	13
3.2	Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж .....	13
3.3	Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	13
3.4	Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	13
3.5	Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
3.6	Түүх, соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөөлөл.....	14
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	15
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
6.	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
7.	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
8.	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
9.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	21
10.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
11.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	23

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн хэрэгжүүлэгчийн тодорхойлт.....	3
Хүснэгт 2. Үйлдвэрийн хүчин чадал.....	4
Хүснэгт 3. Амьтны аймгийн тойрог.....	11
Хүснэгт 4. 2023 оны Менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	15
Хүснэгт 5. 2023 оны Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.....	16
Хүснэгт 6. 2023 оны Цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 7. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	19
Хүснэгт 8. 2023 оны Хог хаягдлын төлөвлөгөө.....	20
Хүснэгт 9. 2023 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	21
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
Хүснэгт 11. Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	23

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн харагдах байдал.....	3
Зураг 2. Түүхий эд.....	5
Зураг 3. Дахин боловсруулсан хуванцар.....	6
Зураг 4. Химийн бодисын сав, уутыг урьдчилан боловсруулах шугам.....	7
Зураг 5. Үйлдвэрийн технологийн саарал ус цэвэршүүлж дахин ашиглах байгууламжийн барилга.....	7
Зураг 6. Төслийн байршил.....	8

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

*Хүснэгт 1. Төслийн хэрэгжүүлэгчийн тодорхойлт*

Төслийн нэр:	“Химийн хуванцар сав баглаа боодол, дахин боловсруулах эко үйлдвэр” төслийн тодотгол
Төслийн дугаар:	2017/АЗ-32
Төсөл хэрэгжүүлэгч:	“Цэцүүх Трейд” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011026056
Регистрийн дугаар:	2066521
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Цэцүүх оффис, үйлдчилгээний төв. Утас: 70179777, 70187798, 70179677
Утас:	976-99057786

Байрлал: Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг, Налайхын 4-р зөрлөгөөс ~500м, Замын үүд явах босоо тэнхлэгийн авто төв замаас ~800м

Газрын хэмжээ: 5 га

Барилгын хэмжээ:

\*Үйлдвэрийн барилга 1378м.кв, оффисын хэсэг 352м.кв, нийт 1730м.кв

\*Саарал ус цэвэршүүлэх барилга: 394.м.кв

\*Агуулахын барилга: 2 барилга\*230м.кв =460м.кв

\*Уурын зуух, гүний худгийн байр: 29м.кв

\*Харуулын байр: 18м.кв

\* 2019.10 сард шинээр нэмж барьсан агуулах: 300м.кв

/ханын доод хэсэг битүү төмөрлөсөн дээд хэсэг торлосон/



*Зураг 1. Төслийн талбайн харагдах байдал*

**Үйлдвэрийн тухай.** Манай компани Төв Аймгийн, Сэргэлэн суманд байрлах “Химийн бодисын сав баглаа боодол дахин боловсруулах” үйлдвэр болон химийн бодисын агуулах байрладаг нийт 10 га талбай газарт Монгол улсын Уул уурхайн компаниудад их хэмжээгээр хэрэглэдэг дотооддоо үйлдвэрлэж болох химийн бодисыг хүн, байгаль орчинд хор аюул багатай технологи ашиглан, санхүүгийн хэмнэлттэй байдлаар үйлдвэрлэх талаар

судалгааг хийн ажиллаж байна. Мөн бид дээрхи өөрийн үйлдвэрийн нийт 10га талбайд олон улсын болон дотоодын стандарт шаардлага, аюулгүй байдлыг бүрэн хангасан химийн бодисын үйлдвэрлэл, тээвэрлэлт, ханган нийлүүлэлт, хадгалалт, химийн бодисын сав баглаа боодлыг цэвэршүүлж, дахин боловсруулах иж бүрэн химийн бодистой холбоотой үйл ажиллагааны цогц парк бий болгохоор ажиллаж байна.

### 1.2 Төслийн хүчин чадал:

Үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, туршилт тохируулгыг хийх ажлыг 2018 оны 6 дугаар сард гүйцэтгэнэ. Туршилтын үйлдвэрлэлийг 2018 оны 7 дугаар сард явуулж, ажилчдыг дадлагажуулна. Үндсэн үйлдвэрлэлийг 2018 оны 8 дугаар сараас эхлэн явуулж, 2020 онд төслийн хүчин чадалд хүргэхээр төлөвлөв.

Цэцүүх трейд ХХК нь цаашдаа “Химийн бодисын агуулахын парк” байгуулах зорилготой бөгөөд эхний ээлжинд 3 агуулахыг барихаар бэлтгэж ажилдаа орсон болно. Одоогоор өөрийн охин компани болох “Хими сервис” ХХК нь 1200м<sup>2</sup> бүхий 1 ш агуулахыг барьж ашиглалтанд оруулхад бэлэн болсон.

Үйлдвэрийн ажлын горим нь, жилд ажиллах сар 12,7 хоногийн ажлын өдөр 6, хоногт ажиллах ээлжийн тоо 2, ээлжийн ажиллах цаг 8 байна. Тус үйлдвэр 2018 онд 1 ээлжээр, 2019 оноос 2 ээлжээр ажиллах бөгөөд суурилагдах машины цагийн бүтээмжийг үндэслэн, үйлдвэрлэлийн төслийн хүчин чадлыг технологийн шугам тус бүрээр тооцож, дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт2. Үйлдвэрийн хүчин чадал*

Д/д	Үйлдвэрлэлийн шугамын нэр	Хүчин чадал,тн		
		Ээлжийн, кг	Сарын	Жилийн
1	PP уутыг бутлах угаах	480,0	24,5	269,3
2	PE савыг бутлах, угаах	3520,0	179,5	1974,7
3	Үрэл үйлдвэрлэх	3400,0	173,4	1907,4

Агуулахын байр нь төвийн халаалттай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, хүрэлцээтэй,агаар сэлгэх салхивчтай, агааржуулах хоолойтой, гар угаагуур байрлуулсан агуулахын гадуур цементэн бетон хашаатай бөгөөд агуулахын байр нь 24 цагийн харуул хамгаалалттай байна.

### 1.3 Төслийн технологи:

Хоёрдогч хуванцар үрэл үйлдвэрлэл нь ашиглагдсан химийн бодис, материалын сав, уутыг хэрчих, угаах, бутлах, хатаах, халаах, зүсэх, тасдах, хөргөх, савлах зэргээр тэдгээрийн физик, химийн шинж чанарыг хувиргахгүйгээр механик боловсруулалт хийж, хэлбэр дүрсийг нь өөрчлөн түүхий эд болгох үйл явц юм.

Хуванцар үрэл үйлдвэрлэх технологи нь дараах дамжлагуудаас бүрдэнэ.

Сав, уутыг төрөлжүүлэн ялгаж, шахаж нягтруулна.

**II.** Шахаж нягтруулсан түүхий эдийг жинлэнэ.

**I** Жинлэсэн түүхий эд тус бүрийг (сав, уут) жижиглэн хэрчиж, угаах машинд оруулна. Энэ дамжлагаар түүхий эдийг шороо, тоос, механик хольцоос салгана.

**V** Жижиглэгдэж угаагдсан түүхий эдийг бутлаж, угаана. Энэ дамжлагаар түүхий эдэд үлдсэн бохир нь механикаар бүрэн шигшигдэж цэвэрлэгдэнэ.

- V .Бутлагдаж, цэвэрлэгдсэн түүхий эдийг хатаана.
- VI . Хатаагдсан түүхий эдийг жигнэх аргаар халааж хайлмаг болгоно. Энэ дамжлагаар хайлмагаас хортой бодисуудыг сорж авна.
- VII . Хайлмагийг нарийхан хуванцар утас хэлбэрээр зүснэ.
- VIII Утас хэлбэртэй хуванцрыг 3-5 мм-ийн урттайгаар таслана. Энэ дамжлагаар Хуванцар үрлүүд бий болно.
- IX Хуванцар үрлүүдийг хөргөх цамхагт оуулан хөргөнө.
- X. Хөрсөн үрлийг шуудайнд савлаж, бэлэн бүтээгдэхүүн болно.
- XI. Савласан бүтээгдэхүүнийг агуулахад хураана. Бүтээгдэхүүний гарц нь 85% буюу 1 тн түүхий эдээс 850 кг бүтээгдэхүүн гарна.

#### 1.4 Түүхий эд, туслах материал:

Төслийн үйлдвэрлэлийн түүхий эд буюу үндсэн материал нь химийн бодис, бүтээгдэхүүний полиэтилен сав, полипропилен уут болно. Монголын ХХДБҮХ-ны мэдээгээр манай улсын хэмжээнд жилд дунджаар 1,4 сая гаруй тонн хог хаягдал үүсдэг бөгөөд үүний 20-30 хувийг хуванцар сав, уут эзэлдэг ажээ. Импортоор авдаг нийт хуванцар савтай химийн бодис, бүтээгдэхүүний 97 хувийг БНХАУ-аас оруулж ирдэг бөгөөд үүний 91 хувь нь 30 литрээс бага багтаамж бүхий сав, уут байна. Үүнээс харахад дээрхи сав, уутны нөөц олон арван мянган тн-оор хэмжигдэхээр байна.

2016, 2017 онд улсын хэмжээгээр импортлосон техникийн ангиллын үйлдвэрлэлийн зориулалттай хуванцар бодисын сав, уут 8897768 ширхэг буюу 3330 тн болж байгаа нь төслийн үйлдвэрийн түүхий эдийн хэрэгцээг 1,5 жил хангах хэмжээ юм.

Цэцүүх трейд компани нь улсын хэмжээнд импортоор оруулж ирж байгаа үйлдвэрлэлийн технологийн бодисын дөнгөж 4 хувь буюу уул уурхайн болон ДЦС, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн технологид хэрэглэдэг техникийн ангиллын химийн бодисыг хангаж байна. Тус компанийн 2016, 2017 онд импортлосон техникийн ангиллын үйлдвэрлэлийн зориулалттай хуванцар бодисын сав, уут 358669 ш буюу 129 тн болж байна. Энэ нь төслийн үйлдвэрийн түүхий эдийн хэрэгцээг 1 сар хангах хэмжээ болно.



Зураг2. Түүхий эд

### 1.5 Эцсийн бүтээгдэхүүн

Төслийн үйлдвэр ашигласан полипропилен, полиэтилен уут, савыг дахин боловсруулж, хоёрдогч хуванцар үрэл үйлдвэрлэнэ.

Полипропилен, полиэтилен үрэл нь хөнгөн, хийсэн материалынхаа өнгө, физик, химийн шинж чанарыг хадгалсан, цилиндр хэлбэртэй, цагаан будааны хэмжээтэй хуванцар болно. Эдгээр хуванцарууд нь ус, цахилгаан нэвтрүүлдэггүй, дулаанаа сайн хадгалдаг, хэвэнд сайн ордог, уян, азотын болон хүхрийн хүчлээс бусад хүчил, шүлтэнд тэсвэртэй, олон удаа дахин боловсруулах, мод, төмрийг орлуулах боломжтой зэрэг нийтлэг шинж чанартай түүхий эд юм.



Зураг 3. Дахин боловсруулсан хуванцар

### 1.6 Тоног төхөөрөмж

Төслийн үйлдвэрлэлийг явуулахад дараах машин, тоног төхөөрөмжүүд шаардлагатай. Үүнд:

Төслийн үйлдвэрт БНХАУ-ын компанийн хуванцар сав, уутыг дахин боловруулах үйлдвэрлэлийн шугамыг суурилуулна.

- < Хуванцар уутыг бутлах, угаах шугам
- < Хуванцар савыг бутлах, угаах шугам
- < Үрэл болгох шугам
- < Хайлуулалтаас гарах хийг шүүх, зайлуулах төхөөрөмж
- < Технологийн ашигласан усыг цэвэршүүлэх төхөөрөмж зэрэг болно.
- < Сэрээт ачигч 1, түүхий эд зөөх, бэлэн бүтээгдэхүүнийг хураах, ачих

Үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжүүдийн зураг, үнийн санал, техникийн үзүүлэлтийг 2 дугаар хавсралтад үзүүлэв.

### Тээврийн хэрэгсэл

< Хүнд (35 тн) даацын ачааны автомашин 3 (одоогоор 1 автомашиныг ашиглаж байгаа, 2019 онд 2 автомашиныг шинээр худалдаж авна), үйлдвэрлэлийн түүхий эдийн хангамж, бүтээгдэхүүний борлуулалтад хэрэглэх.

< Дунд оврын автобус 1 (2018 онд түрээсээр автобус ашиглаж, 2019 онд шинээр худалдаж авна), ажилчдыг зөөх болон аж ахуйн хангамжид хэрэглэх.

< Суудлын машин 1, удирдлагын өдөр тутмын ажил болон аж ахуйн хангамжид хэрэглэх

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ



Зураг 4. Химийн бодисын сав, уутыг урьдчилан боловсруулах шугам

### 1.7 Хог хаягдал

Төслийн технологийн нүйлжиллагаанаас хатуухаягдал гарахгүй бөгөөд зөвхөн ахуйн гаралтай хатуухог хаягдал гарна.

**Ахуйн хатуухог хаягдал:** Төслийг хэрэгжүүлэх явцад маш бага хэмжээтэй ахуйн хог хаягдал гарна. Жилд 1-1.5тн орчим ахуйн хог хаягдал гарах бөгөөд үүнийг Төв аймгийн Сэргэлэн сумийн ТҮК-тэй гэрээ хийн зайлуулна.

### Усны хэрэглээ ба ахуйн шингэн хаягдал

Талбай: 32м х 12м = 384м<sup>2</sup>,

Зоорь: 4м-н гүнтэй хэрээсэн арматур бүхий өндөр маркийн бетоныг химийн тусгай зориулалтын бодисоор нягтаршуулсан 40см-н зузаантай шал, хана бүхий 5 тасалгаатай Үйлдвэрийн технологийн ашиглагдсан саарал усыг цэвэршүүлж дахин ашиглах байгууламжийн тоног төхөөрөмж, Гүний 1 худагтай.




Зураг 5. Үйлдвэрийн технологийн саарал ус цэвэршүүлж дахин ашиглах байгууламжийн барилга



## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төв аймаг, Сэргэлэн сум 1-р баг, Налайхын 4-р зөрлөгийн зүүн талд байрлана.



Зураг 6. Төслийн байршил

### 2.1 Уур амьсгал

Цаг уурын хувьд Монгол оронд ноёлох эх газрын эрс тэс уур амьсгал зонхилох бөгөөд энэ нь хоног, улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй, жилд унах тунадасны хувиарлалт жигд бус, хуурай, сэрүүн байдгаараа тайлбарлагдана. Агаарын дундаж температур 7 дугаар сард агаарын дундаж температур +250С, 1 дүгээр сард -27,40С байна. Жилд дунджаар 240 мм тунадас унах ба үүний 70-75% нь 4-10 саруудад буюу ургамал ургалтын үед унана. Салхины жилийн дундаж хурд 2.3 м/сек ба ноёлох чиг нь хойд ба баруун хойд зүг.

### 2.2 Геологийн тогтоц ба геоморфологи

Төсөл хэрэгжих талбай нь 1400 метрийн өндөрлөг бүхий геоморфологийн хувьд сибирийн геоморфологийн их мужийн Хангай, Хэнтийн уулархаг, Дорно Монголын талархаг мужид багтана. (Цэгмид, 1987) Төслийн ойр орчимд тархсан хотгор гүдгэрийг морфогенетик хэв шинжээр нь:

1. Тектоник элэгдлийн хэв шинжит хотгор гүдгэр
2. Элэгдэл-хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэр гэсэн 2 үндсэн хэв шинжид ангилан ялгаж болно

Тектоник-элэгдлийн хэв шинжит хотгор гүдгэрт - дундаж өндөр болон нам уулс хамрагдах ба эдгээр нь анх тектоник хөдөлгөөнөөр үүсч өргөгдсөн боловч хожим гадаад хүчний нөлөөгөөр элэгдэн өөрчлөгджээ. Энэ хэв шинжийн уулс нь үнэмлэхүй ба харьцах өндрөөрөө, морфологи хэлбэр дүрсээрээ өөр хоорондоо ялгарах тул дотроо 2 дэд хэв шинжийг үүсгэнэ.

1. Дунд зэрэг хэрчигдсэн хавтгай, бөмбөгөр оройтой налуувтар хажуутай дундаж өндөр уул (Н=1500-1800 м, h=300-400м)

Энэ дэд хэв шинжийн уулсад Эрдэнэ, Ар толгой, Аргуулын ар хөтөл болон Шаварт, Шивэртийн голын ус хагалбарын бэсрэг уулс хамрагдана.

Уулсын орой хяр хавтгайдуу мөлгөр хэлбэртэй. Хажуу нь харилцан адилгүй буюу эгцдүү, налуувтар байх бөгөөд ихэвчлэн ой модоор битүү хучигдсан байна. Уулс нь ойн хилээс дээш гарахгүй гол төлөв 1500-1800 метрийн хооронд хэлбэлзэх ба 300-400 метрийн харьцах өндөртэй байна. Уулсын орой, хажуугийн дээд хэсэгт хадан цохиотой. Хажуу нь гол, горхи, ам хөндийгээр нилээд шигүү хэрчигдсэн байдаг.

2. Хүчтэй хэрчигдсэн шовхдуу, бөмбөгөр оройтой, хад чулуурхаг эгц хажуутай нам уул (Н=1200-1400 м, h=100-300м), Ийм дэд хэв шинжийн уулс нь дээр дурьдсан уулсын ойролцоох голын болон уул хоорондын хөндий рүү шувтрах үзүүрт тархана. Тухайлбал Шавартын голын 2 тал руу бууж ирсэн Морин толгой (1212.0) зэрэг хэд хэдэн нам уулсыг дурьдаж болно. Эдгээр нам уулсын хооронд дурьдсан голуудын хөндий оршино. Элэгдэл, эвдрэлд нилээд автсан ийм нам уулсын хажуу нь эгц бөгөөд гуу жалга, гол горхиор их хэрчигдсэн байдаг. Ийм нам уулсын гадаргад суурь чулуулаг ил гарч хадан цохио үүсгэсэн байх нь элбэг тохиолдоно. Өндрийн хувьд 1000-1500м, харьцах өндөр нь 100-400 м байна.

Хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэр - Хараа голын томоохон цутгал болох Бороо голын баруун талын цутгал жижиг голуудын хөндий дагуу тархана. Энэ хэв шинжийн хотгор гүдгэрийн бүрэлдэн тогтоход тектоник нөлөө харьцангуй бага, харин гадаад хүчин зүйл давамгайл үүрэг гүйцэтгэсэн, өөрөөр хэлбэл урт удаан элэгдлийн үр дүнд үүсч хуримтлагдсан хэлбэрүүд юм.

Ийм хотгор гүдгэрийг дотор нь голуудын хурдаст тал (татмын, нам дэнжийн, хөндийн ёроолын), пролювийн хурдаст тал, аллюви-пролювийн хурдаст тал гэсэн дэд хэв шинжүүдэд хуваана. Хотгор гүдгэрийн энэ дэд хэв шинжээс энэ нутагт делюви-пролювийн болон аллюви-пролювийн хэвгий тал тархжээ. Хоногийн агаарын температурын хэлбэлзэл, нар салхины нөлөөгөөр уул нурууг бүрдүүлэгч суурь чулуулаг өгөршин үйрч урсгал ус, хүндийн хүчний нөлөөгөөр хажууг даган гулсаж бэл хормойн ийм хэвгий талыг үүсгэдэг байна.

### 2.3 Гадаргын ус

Төв аймгийн гадаргын усны эх үүсвэр болох Хэрлэн, Туул зэрэг том жижиг 30 гаруй голтой. Жанчивлан, Цайдам, Цахир зэрэг бүрд нууруудтай. Одоогоор Архуст сумын гадаргын усны ганц эх үүсвэр болох Галуутын гол сумын зүүн урд хэсгээр урсан өнгөрдөг. Төсөл хэрэгжих талбайн хамгийн ойрхон усны эх үүсвэр 3 км зайд орших гүний худаг байсан. 1961 онд хийгдсэн Монгол орны байрзүйн зурганд төслийн талбайд түр урсацтай Хар хустын горхи урсдаг байсан. Архуст сумын Нарст 2 дугаар багийн нутагт 1200 л/цаг ундратай булгаас эх авсан Ар хустын амын горхи одоогоор урсгалтай байдаг.

## 2.4 Газрын доорх ус

Төсөл хэрэгжих талбай нь Хангай-Хэнтийн гидрогеологийн массивт хамаарагдах бөгөөд газар доорх ус агуулагч чулуулаг нь сэвсгэр мезо-кайнозойн, интрузивын ан цавын болон палеозойн тунамал-хувирмал чулуулгаас тогтоно (Г. Туваанжав, 2017).

Энэ районд дараах уст үе тархсан байна. Үүнд:

- ✓ Делюви-пролювийн хурдасны уст үе
- ✓ Протерозой-палеозойн хурдсны ан цавын бүс дэх уст комплекс
- ✓ Интрузив гаралтай, ан цавын бүс дэх газар доорх уст комплекс.

Интрузив гаралтай хурдсын ан цавын бүс дэх газар доорх ус

Интрузив гаралтай хурдсын ан цавын бүс дэх газар доорх ус нь тухайн бүс нутгийн хувьд мөн л хангалттай тархсан. Ус орших нөхцөл, газар доорх усны хөдөлгөөн нь ан цавын бүсийн шинж чанараас ихээхэн хамаарна. Ус агуулах зузаалаг нь харьцангуй бага, хэдхэн арван метрээс үл хэтэрнэ. Газар доорх усны тэжээгдэл нь агаарын хур тунадасны шүүрэлт, зайлуулагдалын муж нь гипсометрийн хувьд түүний дор орших бусад уст үе, давхарга болох ба мөн хагарал, ан цаваас илрэх булаг болно. Энэ комплекст илэрсэн уст цэгүүдийн ундарга нь 0.4-150.0 л/с байна

## 2.5 Хөрсөн бүрхэвч

Сумын хөрсөн бүрхэвчинд ойт хээрийн хар хүрэн хөрс зонхилно. Энэ хөрс нь газарзүйн мужлал, гарал үүслийн хувьд нугат хээрийн хар шороон хөрснөөс цөлөрхөг хээрийн бор хөрсөнд шилжих завсрын шинж чанарыг агуулах ба ойт хээрийн аядуу зөөлөн чийглэг уур амьсгалтай, харьцангуй сайн ургамлан бүрхэвчийн дор үүссэн учраас үржил шим сайтай, зузаан ялзмагийн давхаргатай, хүндэвтэр механикийн бүрэлдэхүүнтэй, үрлэн бөөмөрхөг бүтэцтэй, сулавтар хүчиллэг ба саармагжуу хөрсний орчинтой байдаг. Уулсын хоорондохи ам хөндийгөөр нь улирлын болон мөнх цэвдэгт нугын болон нуга намгийн хөрс нилээд бий.

## 2.6 Ургамлан нөмрөг

Монгол орны ургамал-газарзүйн мужлалын Дундад-Халхын хээрийн тойрогт багтана. Хээрийн судалгаагаар эзэмшил газрын талбайн ургамлан нөмрөг нь жижиг дэгнүүлт үетэн-хялганат, ботууль-алаг өвст ургамлан нөмрөгтэй байна. Ашиглалтын талбайн тус нэгж талбарт Бясаат улалж /*Carex coriophora*/ 25-30%-иар *Cop1* арвитайгаар, Агь /*Artemisa frigida*/, Крыловын хялгана /*Stipa krylovii*/, Хурган шарилж /*Artemisia commutata*/, Ногоон хоног будаа /*Setaria viridis*/, Беллардийн бушилз /*Kobresia billardii*/, Имт гичгэнэ /*Potentilla bifurica*/, зэрэг ургамал

5-10%-ийн бүрхэцтэй *Sp* арвитай, Имт гичгэнэ /*Potentilla bifurica*/ зэрэг ургамал 1-5%-ийн бүрхэцтэй *Un* арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1 м<sup>2</sup> талбайд 25-30%, 10 м<sup>2</sup> талбайд 30-35%, ургамлын дундаж өндөр 2-15 см, зүйлийн тоо 7. Өмнөх жилийн хагд өвс бага зэрэг тархсан. Ширэг улалж /*Carex duriuscula*/, 25-30%-иар *Cop1* арвитайгаар, Дэрвээн хазаар өвс /*Cleistogenes squarrosa*/, Крыловын хялгана /*Stipa krylovii*/, Хялгасан дэвхэргэн цагаан /*Arenaria capilolaries*/, Хурган шарилж /*Artemisia commutata*/, Арзгар согсоолж /*Heteroparus hispidus*/, Ишгүй гичгэнэ /*Potentilla acaulis*/, Имт гичгэнэ /*Potentilla bifurica*/, Бүхэл навчит багдай /*Dontostemon integrifolius*/, Агь /*Artemisa frigida*/, Ленийн ботууль /*Festuca lenensis*/, Ленийн ботууль /*Festuca lenensis*/ зэрэг ургамал 5-10%-

ийн бүрхэцтэй Sp арвитай, Бууралд гандбадраа /Veronica incana/ зэрэг ургамал 1-5%-ийн Un арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1 м2 талбайд 30-35%, 10 м2 талбайд 30%, ургамлын дундаж өндөр 2-20 см, зүйлийн тоо 12. Өмнөх жилийн хагд өвс бага зэрэг тархсан. Хүн, малын хөлд бага зэрэг талхлагдсан, Хад чулуу 80-85% тархсан. Талбайн баруун хэсэгт гуу жалгатай. Хүн, малын хөлд бага зэрэг талхлагдсан.

## 2.7 Амьтны аймаг

Төв аймаг нь амьтны аймгийн мужлалын хувьд Монгол Дагуурын тойрогт хамаарна. Төв аймагт буга согоо, хандгай, аргаль угалз, хойлог, хун зэрэг 16 зүйлийн дархан цаазат амьтдаас гадна хэрэм, тарвага, үнэг, хярс, гахай, баавгай, шилүүс зэрэг агнуурын ач холбогдолтой 30 гаруй төрлийн араатан, жигүүртэн бий.

*Хүснэгт 3. Амьтны аймгийн тойрог*

1. Хөвсгөл орчмын тойрог	6. Баруун хойд Монголын тойрог
2. Хэнтийн тойрог	7. Хойд говийн тойрог
3. Баруун Хянганы тойрог	8. Говь-Алтайн тойрог
4. Монгол Дагуурын тойрог	9. Алтайн өвөр говийн тойрог

## 2.8 Нийгэм, эдийн засаг

Төв аймгийн Сэргэлэн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Дархан гүний хошуу. Баян бүрд, Хайрхан, Хөшиг, Эрдэнэ-Уул, Авдар гэсэн 5 багийн нийт 720 өрхөд 2016 хүн амьдардаг. Улаанбаатар хотоос 62 км, Төв аймгийн төв Зуунмод хотоос 18 км зайд байрладаг. Нийт хүн амын 46 хувь нь сумын төвд амьдардаг. Сумын хүн амын 60 хувь нь залуу болон дунд насныхан, 25 хувь нь хүүхэд, 15 хувь нь хөгшид байна.

### ХҮН АМ

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны эхний 3 сард төрсөн хүүхэд 314, нас барсан хүн 155, бусад аймаг хотоос шилжин ирсэн 386 хүн бүртгэгдсэн. Төрсөн хүүхдийн 63.1 хувь, нас барсан хүний 111.6 хувь нь хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-д оруулжээ. Улсын төсөвт 2022 оны эхний 3 сард 17.6 сая төгрөг төвлөрүүлсэн нь 2021 оны мөн үеэс 7.6 хувь буюу 1.4 сая төгрөг, Орон нутгийн төсөвт 2022 оны эхний 3 сард 5.2 сая төгрөг төвлөрүүлсэн нь 2021 оны мөн үеэс 14.8 хувиар буюу 906.0 мянган төгрөгөөр тус тус буурсан.

### НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2022 оны эхний 3 сард НДШ-ийн орлого 6.8 тэрбум төгрөг болж төлөвлөгөө 114.8 хувь биелэсэн. Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 473400 төгрөг болсон.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 34.3 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 27.6; тэтгэмжийн даатгалын сангийн 74.2; эрүүл мэндийн даатгалын сангийн 147.4; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 31.4; ажилгүйдлийн даатгалын сангийн 40.1 хувийг тус тус бүрдүүлжээ.

## НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2022 оны эхний 3 сарын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 63748 хүнд олгож, 14.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь 2021 оны мөн үеэс хүний тоо 54.8 хувь 22558 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 23.0 хувь 2.8 тэрбум төгрөгөөр тус бүр өссөн. Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 284200 төгрөг болсон.

## ЭРҮҮЛ МЭНД

2022 оны эхний 3 сард 5245 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.5 ор хоног ногдлоо. Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2022 оны эхний 3 сард 184 хүүхэд мэндэлсэн нь 2021 оны мөн үеэс 124 хүүхдээр буурсан. Эмнэлгийн мэдээгээр 2022 оны 3 сард 139 хүн нас барсан нь 2021 оноос 64.0 хувиар өслөө. Нас барсан хүний 23.0 хувь буюу 32 нь эмнэлэгт нас барсан.

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

2022 оны 4 сарын 1-ний байдлаар төллөх насны хээлтэгчийн 29.5 хувь 674.8 мянган хээлтэгч мал төллөж, 679.4 мянган төл гарсны 99.2 хувь 676.3 мянган төл бойжиж байгаа нь 2021 оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 43.0 хувь буюу 203.0 мянгаар; бойжиж буй төл 45.3 хувь буюу 210.7 мянган төлөөр тус бүр өсч; 2013- 2021 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 76.7 хувь 292.9 мянгаар, бойжиж буй төл 77.6 хувь 295.6 мянгаар тус бүр өслөө. Оны эхний төллөх насны ингэний 7.6; гүүний 2.2; үнээний 6.6; эм хонины 33.5; эм ямааны 31.7 хувь нь тус бүр төллөв.

## АЖ ҮЙЛДВЭР

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2022 оны эхний 3 сард (2015 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 12.2 тэрбум төгрөг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2021 оны мөн үеэс 4.8 хувь буюу 618.9 сая төгрөгөөр буурлаа. Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь ашигт малтмал олборлолт, өмнөх оноос 11.4 хувь буюу 934.6 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлөв. 2022 онд нийт үйлдвэрлэлтэд боловсруулах үйлдвэрлэл 15.9, дулааны эрчим хүч 24.5, ашигт малтмал олборлолт 59.6 хувийг тус тус эзлэв.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

Энэхүү бүлэгт төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд түүнд өртөх газрын гадарга агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхой тусгана.

Уг төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Тус төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусагдахуун нь агаар, хөрс, ус, газрын гадарга, ургамал юм.

#### 3.1 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн явцад агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь барилгын ажлын нөлөөгөөр үүсэх тоосжилт байх юм. Тоосжилтын эх үүсвэрүүд нь:

- Үйлдвэрт ашиглагдаж байгаа машин механизмын засвар үйлчилгээ, тохижилтын барилгын ажлын явц дахь газар шорооны ажилд агаар орчин бохирдох
  - Үйлдвэрийн дотоод орчиноос гадагш агаарын бохирдол алдагдах
- Төслийн талбайд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тухайн тоосжилтийн түвшинг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болох бөгөөд агаарт дэгдэж буй тоосны улмаас үзэгдэх орчин багасаж осол, аваар гарч болзошгүй.

#### 3.2 Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Төслийн талбай нь гүний худагтай учир гадаргын усанд сөрөг нөлөөлөл байхгүй.

#### 3.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Үйлдвэрийн хашаан доторх хөрсний байгалийн элэгдэл эвдрэлийн үйл явц харилцан адилгүй хэлбэрээр тохиолдох ба хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс хүчтэй эвдрэлд орсон газар байхгүй.
- Дахин боловсруулах хашааны гадна, дотор явган хүний болон автозам тавихад ашиглагдах чулуу, шороо, цемент хийцийн үлдэгдлээр орчны хөрс бохирдоно. Мөн хөрсөнд эдгээр бохирдол нэвчих талтай.
- Хамгаалалтын сахиул айл, машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдоно.
- Хөрс их хэмжээгээр эвдэрч, бүтэц шинж чанараа алдан ургамлан нөмрөгөө устгуулах ба улмаар хөрснөөс хийсэх шорооны хэмжээ ихсэж цөлжилтийн үйл явцыг түргэсгэх болно.

#### 3.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ургамлан бүрхэвч нь мал болон зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс үүсгэгч, бэхжүүлэгч экосистемийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Ургамал нөмрөгийн талхагдал дунд зэрэг буй энэ орчимд хүн болоод техникийн нөлөөтэй талхагдалд ороогүй байна.

- Ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүд нь үйлдвэрийн барилгын ажлын явц, шороон зам, машин, хүний үйл ажиллагаанаас уг талбайнуудын ургамлын нөмрөг бүр мөсөн устах юм. Бүр мөсөн устах ургамлаас гаднах талбайн ургамлууд тоосжилт ба талхагдлаас шалтгаалж ургац бүтээмж доройтож, шарилж, лууль зэрэг хүмүүнсэг ургамал нэмэгдэх сөрөг нөлөөтэй. Үүнээс гадна барилгын ажлын явцад ургамлын нөмрөгийн болзошгүй хувьсал өөрчлөлт нь дараах хүчин зүйлээс шалтгаална. Үүнд:
- Хэт хуурайших, усан хангамж багасах, үер усны аюул нэмэгдсэнээс хөрсөн орчин өөрчлөгдөх хандлагатай болсон.
- Үйл ажиллагаа, автомашины замын тоос зэрэг нь ойр орчмын агаарыг тоосжуулахаас гадна, ургамлын навч бие эрхтэнд шороон тоос цугларч үйлдвэрийн болон түүний ойр хавийн ургамлын цаашдын амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Ургамлын ургац, үйл ажиллагаа явуулж буй хэсэгт бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхагдаж орсон хэсэгт хогийн ургамал ялангуяа шарилж ихээр ургаж хүн амьтаны амьсгалд тоосны аллерги үүсэх үндэстэй.
- Ургамлын бүрхэвч муудах устах зэргээс өвсөн тэжээлтэн амьтад устаж, тэдгээрийг барьж иддэг махчин амьтад ч дүрвэн зайлна.

### 3.5 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Машин техникийн нөлөөгөөр тухайн орчин тархсан хөхтөн амьтад дайжих, шувууд үргэх зэрэг нөлөөлөлтэй.

- Үйл ажиллагаанаас жижиг мэрэгч амьтдын хувьд дуу чимээ, тоос шороо сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.
- Хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн, янз бүрийн таагүй үнэр, гэрэл эрс нэмэгдэж тухайн нутаг болон орчны бүс дэх амьтдын тайван байдал алдагдаж, дүрвэн зайлж байршил нутгаа өөрчилнө.
- Тоосжилтоос орчны бэлчээрийг бохирдуулж мал болон өвсөн тэжээлт амьтдыг ямар нэг хэмжээгээр хордуулна.
- Машин техник олшрох тутам орчны хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн талхигдал ихсэж амьтад амьдрах боломжгүй болно.
- Цахилгааны болон холбооны шугамуудад шувуу гэмтэх, үхэх тохиолдол олширно.
- Химийн бодис тээвэрлэх, ажилчид ажилдаа явах үед замын хөдөлгөөн ба замын дундаж хурд зэргээс амьтад авто машинд дайрагдах эрсдэл нэмэгдэнэ.
- Хөрсний бичил биетэн, шавж олноор устаж үгүй болно.

### 3.6 Түүх, соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөөлөл

Тухайн төсөл хэрэгжих талбай болон ойр орчим ямар нэгэн түүхийн дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын дурсгалт зүйлс болон археологийн олдворт ямар нэгэн байдлаар нөлөөлөл байхгүй. Гэвч төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдох аваас холбогдох хууль тогтоомжид заасны засаг захиргааны анхдагч нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Цэцүүх трейд” ХХК-ын хэрэгжүүлж буй “ХИМИЙН ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР” төслийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. БОМТ-ний хүрээнд авч хэрэгжүүлэхэд 5,128,000 зарцуулахаар байна.

*Хүснэгт 4. 2023 оны Менежментийн төлөвлөгөөний нийт зардал*

№	Зардлын ангилал	2023 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	710,000
2	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн зардал	3,820,000
3	Хог хаягдал	360,000
4	Удирдлага зохион байгуулалт	-
5	ОХШХ	238,000
6	Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	-
Дүн		5,128,000



## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“ХИМИЙН ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР” төслийн БОННУ-ний явцад тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээсурьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримтбичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

*Хүснэгт 5. 2023 оны Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө*

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>								
Үйлдвэрийн дотоод орчны агаар ажиллагсад сөргөөр нөлөөлөх	Агааржуулалтын системийн найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх	Дахин боловсруулах үйлдвэр	Дотоод төлөвлөлтөөр				2023 он	“Агаарын тухай” хууль, 2012 он MNS 5365:2004 “Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга”;
Хаягдал хогийг дахин боловсруулах луу зөөх үед Машин механизмын хөдөлгөөн,	Тээврийн хэрэгсэл зорчих хэсгүүдэд тэмдэглэгээ хийх	Төслийн талбай	ш	40,000	4	160,000	2023 он	MNS5885-2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн Ачих, буулгах ерөнхий шаардлага”
Ачих, буулгах ерөнхий шаардлага” явцад химийн бодис алдагдах	Тасалгааны температур болон уур амьсгал хэмжигч багаж	Төслийн талбай орчимд ашиглах	ш	150,000	2	300,000	2023 он	MNS5885-2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн Ачих, буулгах ерөнхий шаардлага”
<b>Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>								
Хөрсний эвдрэл, бохирдол, доройтол,	Үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжөөс гарах хатуу болон ахуйн хуурай хог хаягдал, химийн бодисын	Дахин боловсруулах үйлдвэрийн бүхий л хүрээнд	Дотоод зардалаар тооцох				2023 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН “ХИМИЙН ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР” ТОДОТГОЛ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ							2023 он	
	хаягдлыг эмх цэгцтэй хадгалах, ангилах, тээвэрлэх						үзүүлэлтийн норм”	
Дахин боловсруулах үйлдвэрийн тээвэрлэлтийн зам талбай	Төслийн талбайн ачиж буулгах талбайг цементжуулах	Төслийн талбай доторх	Дотоод төлөвлөлтөөр зардал тусгах					
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө								
Тоос, дуу шуугиан зэрэг техноген нөлөөлөл нь ургамлан нөмрөг тоос шороонд дарагдах, стрессдэх зэргээр байгалийн аясаар нөхөн сэргэх, ургах үйл явцад сөрөг нөлөө үзүүлнэ.	Орчныг зүлэгжүүлж тохижуулах, мод тарих	Төслийн талбай доторх	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан болно.			2023 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж	
Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулж, байнгын бэлэн байдалд байлгах,	Галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, санамж, зурагт хуудас бэлтгэж байрлуулах	Үйлдвэр дотор	ш	5	50,000	250,000	2023 он	Гамшгаас хамгаалах хууль
Ажлын байранд нарийн дэг журам тогтоож, тамхи татах тусгай байр, галтай ажил, хийн ба цахилгаан гагнуурын ажлыг аюулгүйн	Ил задгай гал гаргахгүй байх зарчмыг баримтлан зохион байгуулж ажиллуулах,	Төслийн талбай	Дотоод зардалдаа зайлшгүй төлөвлөн тусгах			2023 он	Барилгын норм дүрэм, хөдөлмөрийн тухай хууль, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, галын аюулгүй байдлын тухай хууль	

<b>ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК-ИЙН “ХИМИЙН ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР” ТОДОТГОЛ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	2023 ОН
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------

нөхцлийн дагуу боловсруулсан журмын дагуу хийж,					
Ажилчдыг үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй ажиллах заавар зөвлөмж боловсруулж тайлагнах	Үүсч болох эрсдэлээс сэргийлэх	Үйлдвэр дотор	Дотоод зардалдаа зайлшгүй төлөвлөн тусгах	2023 он	MNS 5145 : 2002 – Стандарт
<b>Нийт зардал: 710,000</b>					

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Салхины хаалт хамгаалалтанд хашаалж ургадаг мод тарих боломж, туршилтыг судалж нэвтрүүлэх хэрэгтэй. Оффис, ажлын байрны орчимд цэцгийн мандал байгуулах, үйлдвэрээс хязгаарлагдсан талбайд мод тариалах ажлыг нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөөнд тусгасан байх хэрэгтэй. Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Нөхөн сэргээлт, орчны тохижилтыг ерөнхий төлөвлөгөө болон байгаль хамгаалах төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтөд заасан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

Ингэхдээ дараах арга технологийг баримтална.

1. Төслийн хэрэгжилтийн явцад эвдэгдэх бүх талбайн шимт хөрсийг 0.3м-ийн зузаантай хуулан нөхөн сэргээлтэд бэлтгэж Монгол Улсын (MNS 5917:2008) стандартын дагуу хадгалах
2. Нөхөн сэргээлтэд хэрэглэх шимт хөрс нь аль болох байгалийн унаган төрхтэй хөрсний шинж чанартай ойролцоо байвал зохимжтой учир хадгалах, ашиглахдаа анхаарч байх шаардлагатай. Үржил шимт хөрсийг хэт гүн хуулах зэрэг нь үржилшм багатай, хайрга, чулууны агууламжийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй байх бөгөөд органик бодисын агууламжийг нэмэгдүүлэх, чулуулгийг багасгах шаардлага үүсдэг.
3. БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний ургамал, нөхөн сэргээлт, орчны тохижилтын ажлыг гүйцэтгэхдээ дахин боловсруулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зохих стандартын дагуу биологийн нөхөн сэргээлт явуулах арга технологийг баримтлан ажиллана.

Хүснэгт 6. 2023 оны Цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн талбайн хашаалалтын дагуу мод, бут тарих	Шар хуайс	Хашааны дагуу -хуайс	ш	100	10000	1,000,000	2023 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд тарималжуулах	хайлаас тарьж ургуулах	Төслийн талбай дотор хайлаас	ш	80	9000	720,000	2023 он	МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд тарималжуулах	Монгол гацуур	Төслийн талбай дотор гацуур	ш	20	105000	2,100,000	2023 он	МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
<b>Нийт дүн: 3,820,000</b>								

## 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн үйлажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2023 он		Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад		Тухайн үед нь шийдвэрлэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

### 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид 2023 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

*Хүснэгт 8. 2023 оны Хог хаягдлын төлөвлөгөө*

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн гаралтай хог хаягдлыг сар бүр ачуулах	Хог хаягдлыг түр цэгт байршуулах	Төслийн талбайд	ш	30,000	12	360,000	2023 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
Бохир ус соруулах	Бохир усыг удааснаар үнэр гарахаас сэргийлэх	Төслийн талбайд	ш	Дотоод төлөвлөлтөөр шийдэх		2023 он		
<b>Нийт дүн: 360,000</b>								

### 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “ХИМИЙН ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

*Хүснэгт 9. 2023 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ялгарах бохирдуулагчид: SO <sub>2</sub> , CO, NO <sub>2</sub>	Төслийн талбайд 2 байршилд	Жилд 1 удаа буюу 4 болон 10 саруудад дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	2 удаа	55,000	110,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2023 он	MNS 4585:2016,
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах	Төслийн талбайд 2 байршилд	8 сард дээжлэлт хийх	2 удаа	45,000	90,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хийлгэх	2023 он	MNS 5850:2019,
Унд ахуйн уснаас дээжлэлт хийх	Төслийн төвийн гүний худгаас	Жилд 1 удаа	1 удаа	38,000	38,000	Жилд 1 удаа	2023 он	MNS 0900:2005 (MNS 6148:2010)
<b>Нийт дүн: 238,000</b>								

## 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2023 он				
		Сар	Сар	Сар		
Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж байх;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Улирал бүр			Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Гамшгаас хамгаалах тухайхууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын MNS5078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас-Ерөнхий шаардлага
Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах;	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	Жилд 1 удаа			Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	
Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг батлагдсан журмын дагуу жил бүр боловсруулан БОАЖЯ-аар батлуулах;	Дотоод төлөвлөлтөөр	2023 он			Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Мэргэжлийн байгууллагатай хамтран аюултай хог хаягдлыг хог хаягдлын талаар жилд 1 удаа сургалт зохион байгуулах	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	2023 он			Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Хог хаягдлын тухай хууль
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Дотоод төлөвлөлтөөр	2023 он			Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам
Байгаль орчны аудит хийлгэх	Дотоод төлөвлөлтөөр	2023 он			Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Байгаль орчны аудит

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 11. Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Үйлдвэрийн төслийн БОМТБОХ-ыг таниулах, мэдээлэх, тус дүүргийн оршин суугчдад таниулах	Цаасан хэлбэрээр	Төлөвлөгөөт Ажлынтайлан, Биелэлтийнүрдүн,	Жил бүрийн 10 дугаар сард	Дотоод төлөвлөлтөөр	Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	“Цэцүүх трейд” ХХК байр
Үйлдвэрийн харьяаллын дүүргийн ИНХ	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Дотоод төлөвлөлтөөр	Гүйцэтгэх захирал Н.Билгүүн	Төв аймгийн ИНХ-н танхимд